Үндсэн хөрөнгө өссөн нь сумын ЗДТГ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,399.3 сая төгрөгийн Онон голын бетонон гүүр, аймгийн хөрөнгө оруулалтаар 146.0 сая төгрөгийн хөрөнгийг, хандиваар барьсан 35.0 сая төгрөгийн багийн төвийн барилгыг, бараа материалын данснаас 4,000.5 сая төгрөгийн жишиг сумын байгууламжуудыг, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 73.8 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн орлого авч, Сум дундын эмнэлгийн 489.1 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд 115.9 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасан, 3.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

1. Нийтлэг үйлчилгээний газар хөрөнгө шилжүүлэх тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад 2,682.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгасныг санхүүгийн тайланд залруулсан.

### 3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 12.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 0.7 сая төгрөг болж, 11.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Өглөг</b>	<b>3.7</b>	<b>0.0</b>	<b>(3.7)</b>
Ажиллагсадтай холбогдсон өглөг	3.7	0.0	(3.7)
Бараа үйлчилгээний зардлын өглөг			-
<b>Бусад өглөг</b>	<b>8.5</b>	<b>0.7</b>	<b>(7.8)</b>
Байгууллагад төлөх өглөг	1.6		(1.6)
Хувь хүмүүст төлөх өглөг	1.3	0.7	(0.6)
Татварын өглөг /ТӨҮГ/	0.1		(0.1)
Дансны өглөг /ТӨҮГ/	5.5		(5.5)
<b>Нийт дүн</b>	<b>12.2</b>	<b>0.7</b>	<b>(11.5)</b>

Эх сурвалж: Биндэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Биндэр Нийтлэг үйлчилгээний газрын хувь хүмүүст төлөх 0.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна.

### 3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 10,021.9 сая, эцсийн үлдэгдэл 18,456.9 сая төгрөг болж, 8,435.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

/САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>2,765.2</b>	<b>2,777.4</b>	<b>12.2</b>	<b>15.0</b>
<b>Өмч /төрийн/ /ТӨҮГ/</b>	<b>123.2</b>	<b>588.6</b>	<b>465.4</b>	<b>3.2</b>
<b>Хуримтлагдсан үр дүн:</b>	<b>6,425.4</b>	<b>14,238.0</b>	<b>7,812.6</b>	<b>77.1</b>
Өмнөх үеийн үр дүн	5,291.8	6,351.6	1,059.8	
Тайлант үеийн үр дүн	1,133.6	7,886.4	6,752.8	
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>708.1</b>	<b>852.9</b>	<b>144.8</b>	<b>4.6</b>
<b>Дүн</b>	<b>10,021.9</b>	<b>18,456.9</b>	<b>8,435.0</b>	<b>100</b>

Эх сурвалж: : Биндэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс 12.2 сая төгрөгөөр өсөхөд Сум дундын эмнэлгийн 15.6 сая төгрөгөөр нэмэгдэж, Эмийн эргэлтийн сан 3.4 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Өмч /ТӨҮГ/ данс 465.4 сая төгрөгөөр өссөн нь Биндэр нийтлэг үйлчилгээний газрын өмч 94.4 сая төгрөгөөр, Сум дундын эмнэлгийн өмч 370.9 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дахин үнэлгээний зөрүү данс Сум дундын эмнэлгийн 147.7 сая төгрөгөөр нэмэгдэж, Эмийн эргэлтийн сангийн 3.0 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

### 3.5.8 Орлогын данс

Биндэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан дахь 16,041.1 сая төгрөгийн орлогоос татварын орлого 315.2 сая төгрөг, татварын бус орлого 12,239.2 сая төгрөг, тусламж санхүүжилтийн орлого 3,486.8 сая төгрөг байна.

Татварын бус орлогод торгуулийн орлого 30.7 сая төгрөг, төсөвт байгууллагын туслах үйл ажиллагаанаас 33.8 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 11,781.8 сая төгрөг, зээлийн хүүгийн 19.8 сая төгрөг, бусад орлого 100.7 сая төгрөг, ТӨҮГ-ын борлуулалтын орлого 272.4 сая төгрөгийн орлого байна. Үүнд: Нийтлэг үйлчилгээний газар 209.6 сая төгрөг, Сум дундын эмнэлэг 222.3 сая төгрөг, Байгаль хамгаалах сан 11.9 сая, Жижиг дунд бизнесийг дэмжих сан 19.7 сая төгрөг, Засаг даргын Тамгын газар 11,545.7 сая, Ерөнхий боловсролын сургууль 15.6 сая төгрөг, Соёлын төв 2.5 сая, Биндэр Ой анги 165.5 сая, Эмийн эргэлтийн сан 8.1 сая төгрөг, Орон нутгийн орлогод 38.3 сая төгрөгийн орлого хүлээн авсан байна.

### 3.5.9 Зардлын данс

Үйл ажиллагааны нийт зардал 7,889.1 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардал 186.9 сая төгрөг байна. Үйл ажиллагааны бус зардал нь үндсэн хөрөнгийг данснаас хассан болон ОНХС-ийн хөрөнгийн зардалтай холбоотой байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Биндэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 15 дугаар тогтоолд зааснаар төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 181.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 353.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 172.0 сая төгрөгөөр давуулан буюу 194.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

№	Орлогын нэр төрөл	2021 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	27,000.0	34,972.2	7,972.2	129.5
2	Хөрөнгийн орлого	65,000.0	80,461.0	15,461.0	123.8
3	Хөрөнгө борлуулсны орлого	0.0	885.0	885.0	
4	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	200.0	200.0	-	100.0
5	Бууны албан татвар	3,200.0	3,419.0	219.0	106.8
	Малд ногдуулах албан татвар	0.0	114,015.9	114,015.9	
7	Улсын тэмдэгтийн хураамж	7,000.0	6,259.4	(740.6)	89.4
8	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	4,684.1	9,192.8	4,508.7	196.3
9	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,000.0	5,232.6	1,232.6	130.8
10	Газрын төлбөр	3,400.0	4,001.7	601.7	117.7
11	Ойн нөөц ашигласны төлбөр	36,000.0	54,061.9	18,061.9	150.2
12	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	18,003.6	2,178.7	(15,824.9)	12.1

13	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.0	285.0	285.0	
14	Торгуулийн орлого	12,000.0	30,726.0	18,726.0	256.1
15	Бусад орлого	1,000.0	7,593.2	6,593.2	759.3
<b>Нийт дүн</b>		<b>181,487.7</b>	<b>353,484.3</b>	<b>171,996.6</b>	<b>194.8</b>

Сумын төсвийн орлогын биелэлтийг орлогын төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, бууны албан татвар, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хог хаягдлын хураамжийн орлого, газрын төлбөр, хүү торгуулийн орлого, бусад орлого, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого, ан амьтны нөөц ашигласны төлбөр, усны төлбөр, малын албан татварууд давж биелсэн нь төлөвлөгдөөгүй орлого орсон болон орлогын төлөвлөлттэй холбоотой байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 740.6 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөрийг 15,824.9 мянган төгрөгөөр, нийт 16,565.5 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;” заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-аас нийт зардал, эх үүсвэрийг 3,457.8 сая төгрөгөөр, тодотголоор 220.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 3,678.6 сая төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 3,463.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3,112.3 сая төгрөгийг урсгал зардалд, 226.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 125.1 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 705.7 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 705.7 сая төгрөгөөр олгожээ.

Нийт зардлын 2,104.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,012.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 127.8 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангаас, 23.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 131.4 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 64.2 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 2,104.8 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт 1,012.6 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас олгох 127.8 сая төгрөгийг бүрэн санхүүжүүлсэн байна. Эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийг 17.8 сая төгрөгийг олгож, 5.2 сая төгрөгөөр дутуу олгосон байна. Орон нутгийн хөгжлийн санд 113.4 сая төгрөгийн малын албан татварын орлогыг төвлөрүүлж, 0.6 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогод 75.3 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 26.3 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн нь батлагдсан орлогын төлөвлөгөөг Жижиг дунд бизнесийг

дэмжих сан 31.9 сая төгрөгөөр дутуу, Сум хөгжүүлэх сан 5.6 сая төгрөгөөр давуулж биелүүлснээс шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 36.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 6.9 сая төгрөгөөр давсан нь Байгаль хамгаалах сан орлогыг 1.9 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сан 5.4 сая төгрөгөөр давуулж биелүүлснээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,189.2 сая төгрөг буюу 92.1 хувьтай байгаа нь хөрөнгийн зардал 13.2 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх зээл 125.0 сая төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний зардал 113.8 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардал 20.7 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна. Үүнд:

Урсгал зардлын гүйцэтгэлийг авч үзвэл цалин хөлс болон нэмэгдэл урамшил 42.3 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 16.6 сая төгрөгөөр, байр ашиглалтын тогтмол зардал 1.9 сая төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардал 0.6 сая төгрөгөөр, хоол хүнс, нормативт зардлыг 49.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 0.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 78.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 18.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлснийг авч үзвэл Засаг даргын тамгын газар 1.4 сая төгрөгийг, Соёлын төв 9.0 сая төгрөгийг, Иргэдийн төлөөлөгчдийн хурал 8.0 сая төгрөгийг, Сум дундын эмнэлэг 0.1 сая төгрөгийг, Ой анги 0.01 сая төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Мөн тусгай зориулалтын шилжүүлгийн үлдэгдлээс Хүүхдийн цэцэрлэг 33.2 сая төгрөгийг, Ерөнхий боловсролын сургууль 71.3 сая төгрөгийг төгрөгийг, нийт 104.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Орон нутгийн хөгжлийн сангаар 167.1 сая төгрөгийн 15 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 14 ажлыг 153.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлж, 8.0 сая төгрөгийн төсөв бүхий хогийн цэгийн хашаажуулах ажил хийгдээгүй байна.

Эргэж төлөгдөх зээл 125.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Жижиг дунд бизнесийг дэмжих сангаас олгох 51.2 сая төгрөгийн, Сум хөгжүүлэх сангаас олгох 73.8 сая төгрөгийн зээлийг олгоогүйтэй холбоотой байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох зардлыг хэмнээгүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан 10.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:*
  - ЗДТГ 5.6 сая төгрөг
  - Соёлын төв 4.5 сая төгрөг
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй 13.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:*
  - ЕБ-ын сургууль 3.5 сая төгрөг
  - Байгаль хамгаалах сан 10.0 сая төгрөг
- Иргэдийн төлөөлөгчдийн хурал ашиг сонирхлын зөрчилтэй захиргааны шийдвэр гаргаж 0.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.*
- Байгаль хамгаалах санд хууль тогтоомжид нийцээгүй 11.9 сая төгрөгийн орлого бүртгэсэн зөрчилд зөвлөмж хүргүүлжээ.*

5. Малын тоо толгойн албан татварыг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэхдээ 563.5 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлээ.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансанд дээд шатны төсвийн захирагчаас 315,699.6 мянган төгрөгийн хөрөнгө, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 44,349.6 мянган төгрөгийн, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 165.0 мянган төгрөгийн, нийт 360,214.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнд: Сумын ИТХ 3,300.0 мянган төгрөг, Засаг даргын тамгын газар 98,825.0 мянган төгрөгийн, Ерөнхий боловсролын сургууль 20,879.9 мянган төгрөгийн, Сум дундын эмнэлэг 236,101.0 мянган төгрөгийн, Соёлын төв 871.5 мянган төгрөгийн, Цэцэрлэг 236.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшилд 46,267.1 мянган төгрөгийг, нийгмийн даатгалын шимтгэлд 5,896.8 мянган төгрөгийг, байр ашиглалттай холбоотой зардалд 1,500.0 мянган төгрөгийг, хангамжийн бараа материал худалдан авахад 10,376.2 мянган төгрөгийг, эм бэлдмэлийн зардалд 96,859.2 мянган төгрөгийг, хоол хүнсний зардалд 12,234.9 мянган төгрөгийг, эд хогшил авах зардалд 5,798.5 мянган төгрөгийг, томилолтын зардалд 550.0 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 17,262.8 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 14,116.6 мянган төгрөгийг, шагнал урамшуулалд 42,712.0 мянган төгрөгийг зарцуулж, хөрөнгийн зардалд 73,913.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 8,106.0 мянган төгрөгийг төвлөрүүлснээс орон нутгийн төсөвт ЗДТГ 7,992.0 мянган төгрөг, ИТХ 2.7 мянган төгрөг, Соёлын төв 22.1 мянган төгрөг, улсын төсөвт Ерөнхий боловсролын сургууль 89.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### **Аудитын илрүүлэлт:**

- Сумын ЗДТГ нэмэлт дансанд Хурх голын гүүрний хураамжийн орлого 3.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 23.9.3. "хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого" заалтад нийцээгүй зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### **3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

### **Аудитын илрүүлэлт:**

1. Төсвийн төвлөрүүлэн захирагч шилэн дансны цахим хуудсанд 230,678.2 мянган төгрөгийн 48 мэдээллийг мэдээлснээс 3 мэдээллийг хугацаа хоцроож, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, өр үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлээ.

2. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй дараах байгууллагуудад зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:
- Сум дундын эмнэлэг шилэн дансны цахим хуудсанд 295.8 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй.
  - Биндэр Нийтлэг үйлчилгээний газар таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 112.5 сая төгрөгийн 6 худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 182.3 сая төгрөгийн орлогын 17 мөнгөн гүйлгээ, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 6.2 сая төгрөгийн 8 тушаал шийдвэрийг мэдээлээгүй.
  - Биндэр Ой анги таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,059.5 мянган төгрөгийн 1 худалдан авалт, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 31,911.8 мянган төгрөгийн 4 мөнгөн гүйлгээ, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 827.2 мянган төгрөгийн 4 тушаал шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд тус тус мэдээлээгүй.

ЕБС шилэн дансанд мэдээлбэл зохих 619.0 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 189.2 сая төгрөгийн 2 албан шаардлага, 59.1 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилт
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	2	189.2	2	189.2			100
Зөвлөмж	3	59.1	3	59.1			100
<b>Нийт</b>	<b>5</b>	<b>248.3</b>	<b>5</b>	<b>248.3</b>			<b>100</b>

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 төрийн сангийн, 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 тусгайн сангийн нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 төсвийн байгууллага, 1 төрийн сан аудит хийж дүгнэлт гарган, Жижиг дунд бизнесийг дэмжих сан, Байгаль хамгаалах сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангууд аудитын түүвэрт хамрагдсан болно.

Аудитад хамрагдсан харьяа 7 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн. Цэцэрлэгийн санхүүгийн тайланд “Өндөрхаан Итгэл аудит “ ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

“Эмийн эргэлтийн сан” орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй нь цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,015.4 сая төгрөгийн 19 алдаа, зөрчил ХЭА-2022/10/СТА-ТТЗ

илрүүлснээс 2,683.2 сая төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 2.0 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 651.9 сая төгрөгийн 5 зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, 678.3 сая төгрөгийн 9 зөрчилд зөвлөмж өглөө.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүгүй нэгтгэсэн байна. Харьяа байгууллагын үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг нэгтгэхдээ төсөвт байгууллагуудад олгосон урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн 1,126.0 сая төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 18.5 сая төгрөг, нийт 1,144.5 сая төгрөгийг устгах бичилтийг хийж тайланг нэгтгэсэн байна.

### **Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага**

Аудитаар төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага өгөгдөөгүй.

Төвлөрүүлсэн захирагчид 39.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 5 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Биндэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 39.1 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлснээс зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүллээ.

### **3.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитад ирүүлэхдээ Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан заавар журмын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулгыг бүрэн бэлтгэн ирүүлсэн эсэх, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзнэ.

### **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Орлогын данстай холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:** улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 740.6 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөрийг 15,824.9 мянган төгрөгөөр, нийт 16,565.5 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

**1.2. Эрсдэл:** Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлээгүй байх.

**1.3. Өгсөн зөвлөмж:** Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлж ажиллах

**1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

#### **2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: Байгаль хамгаалах санд хууль тогтоомжид нийцээгүй 11,928.1 мянган төгрөгийн орлого бүртгэсэн нь "Ашигт малтмалын тухай" хуулийн 38.1.8-д дахь заалтад нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Байгаль хамгаалах санд "Ашигт малтмалын тухай" хуулийн 38.1.8 дах заалтын дагуу орлогыг төвлөрүүлэх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

### **3 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт : Байгаль хамгаалах сангаас 9,984.8 мянган төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь "Ашигт малтмалын тухай" хуулийн 38.3, 38.4 дэх заалтад нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байх

3.3. Өгсөн зөвлөмж: Байгаль хамгаалах сангаас "Ашигт малтмалын тухай" хуулийн 38.3, 38.4-д зааснаас өөр зардал гаргахгүй байх

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

### **4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт: Малын тоо толгойн албан татварыг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэхдээ 563.5 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

4.2. Эрсдэл: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байх

4.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 60.2. "Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 60.2.8.малын тоо толгойн албан татварын орлого" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж татварын орлогыг Орон нутгийн хөгжлийн санд бүрэн төвлөрүүлж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

### **5. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

5.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроож, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, өр үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг мэдээлээгүй байна.

5.2. Эрсдэл: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй байх.

5.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж ажиллах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	Биндэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b>
2022.03.25			ХЭА-2022/10/СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Биндэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч		<b>сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Ашиг сонирхлын зөрчилтэй захиргааны шийдвэр гаргаж 0.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.	0.4	Төлбөрийн акт тогтоосон	ИТХ-ын нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч Нягтлан бодогч	Б.Биндэръяа Г.Бат-Эрдэнэ
<b>ИТХ-ын зөрчлийн дүн</b>		<b>0.4</b>			
1	Батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох 5.6 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.	5.6	Албан шаардлага өгсөн	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Г.Өнөболд Х.Гангансүвд
2	Нэмэлт дансанд Хурх голын гүүрний хураамжийн орлого 3.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 23.9.3. "хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого" заалтад нийцээгүй байна.	3.7	Албан шаардлага өгсөн	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Г.Өнөболд Х.Гангансүвд
<b>ЗДТГ-ын зөрчлийн дүн</b>		<b>9.3</b>			
1	Бараа материалын дэлгэрэнгүй тайланд 0.3 сая төгрөгийн орлого дутуу авсан.	0.3	Санхүүгийн тайланд залруулсан	Нягтлан бодогч	Д.Одонгэрэл
2	Батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчин 3.5 сая төгрөгийг бага үнэтэй түргэн элэгдэх зүйлээс хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэсэн.	3.5	Албан шаардлага өгсөн	Захирал Нягтлан бодогч	Ж.Ариунтуяа Д.Одонгэрэл
3	Шилэн дансанд мэдээлбэл зохих 619.0 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй.	619.0	Албан шаардлага өгсөн	Захирал Нягтлан бодогч	Ж.Ариунтуяа Д.Одонгэрэл
<b>ЕБС-ийн зөрчлийн дүн</b>		<b>622.8</b>			

Хэнтий аймгийн Биндэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	Өмнөх оны эцэст үлдэгдэлтэй байсан 2 куб/м бүхий хэмжээтэй 600.0 мянган төгрөгийн банзыг нотлох баримтгүйгээр шууд зарлагдаж, нягтлан бодох бүртгэлд тусгасан.	0.6	Төлбөрийн акт тогтоосон	Эрхлэгч Нягтлан бодогч	Э.Алтаншагай Д.Одонгэрэл
2	Тайлант онд 1 хүүхдэд ногдох хоолны зардлыг нормативаас 958.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.	1.0	Төлбөрийн акт тогтоосон	Эрхлэгч Нягтлан бодогч	Э.Алтаншагай Д.Одонгэрэл
3	Жилийн эцэст аж ахуйн материалаас бусад 20,123.7 мянган төгрөгийн материалын үлдэгдлийг тоолж, тооцоо хийж баталгаажуулаагүй.	20.1	Албан шаардлага өгсөн	Эрхлэгч Нягтлан бодогч	Э.Алтаншагай Д.Одонгэрэл
4	Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 16,307.2 мянган төгрөгөөр дутуу байна.	16.3	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч Нягтлан бодогч	Э.Алтаншагай Д.Одонгэрэл
	<b>Цэцэрлэгийн зөрчлийн дүн</b>	<b>38.0</b>			
1	Шилэн дансны цахим хуудсанд 295.8 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.	295.8	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч Нягтлан бодогч	Ц.Өсөхбаяр Б.Энхтуул
	<b>Сум дундын эмнэлгийн зөрчлийн дүн</b>	<b>295.8</b>			
1	Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 4.5 сая төгрөгийг хэмнэлтгүй зарцуулсан.	4.5	Зөвлөмж өгсөн	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Г.Дэлгэрмаа Г.Бат-Эрдэнэ
	<b>Соёлийн төвийн зөрчлийн дүн</b>	<b>4.5</b>			
1	Хөрөнгө шилжүүлэх тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад 2,682.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан.	2,682.9	Санхүүгийн тайланд залруулсан	Нягтлан бодогч	Э.Солонго
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдөж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Захирал Нягтлан бодогч	Г.Баярхүү Э.Солонго
3	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Захирал Нягтлан бодогч	Г.Баярхүү Э.Солонго

Хэнтий аймгийн Биндэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 112.5 сая төгрөгийн 6 худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 182.3 сая төгрөгийн орлогын 17 мөнгөн гүйлгээ, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 6.2 сая төгрөгийн 8 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.	301.0	Зөвлөмж өгсөн	Захирал Нягтлан бодогч	Г.Баярхүү Э.Солонго
	<b>Нийтлэг үйлчилгээний газрын зөрчлийн дүн</b>	<b>2,983.9</b>			
1	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,059.5 мянган төгрөгийн 1 худалдан авалт, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 31,911.8 мянган төгрөгийн 4 мөнгөн гүйлгээ, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 827.2 мянган төгрөгийн 4 тушаал шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд тус тус мэдээлээгүй байна.	38.8	Зөвлөмж өгсөн	Биндэр Ой ангийн дарга, Нягтлан бодогч	Г.Даваажаргал Д.Оюунболд
	<b>Ой ангийн зөрчлийн дүн</b>	<b>38.8</b>			
1	Хууль тогтоомжид нийцээгүй 11928.1 мянган төгрөгийн орлого бүртгэсэн	11.9	Зөвлөмж өгсөн	Сумын Засаг дарга	Э.Мөнх-Очир Х.Гангансүвд
2	Батлагдсан 9984.8 мянган төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй	10.0	Зөвлөмж өгсөн	Сумын Засаг дарга	Э.Мөнх-Очир Х.Гангансүвд
	<b>Байгаль хамгаалах сангийн зөрчлийн дүн</b>	<b>21.9</b>			
1	Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр авч үзэхэд улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 740.6 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөрийг 15,824.9 мянган төгрөгөөр, нийт 16,565.5 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн.	16.6	Зөвлөмж өгсөн	Сумын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	Э.Мөнх-Очир Г.Бат-Эрдэнэ

Хэнтий аймгийн Биндэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	Шилэн дансны цахим хуудсанд 230678.2 мянган төгрөгийн 48 мэдээллийг мэдээлснээс 3 мэдээллийг хугацаа хоцроож, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, өр үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг мэдээлээгүй байна.	-	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	Э.Мөнх-Очир Г.Бат-Эрдэнэ
3	Малын тоо толгойн албан татварыг ОНХС-д төвлөрүүлэхдээ 563.5 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.	0.6	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	Э.Мөнх-Очир Г.Бат-Эрдэнэ
	<b>ТТЗ-ийн дүн</b>	<b>17.2</b>			
	<b>Нийт дүн</b>	<b>4,032.6</b>			